



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 10 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 323


Улаанбаатар
хот

Газрын тос боловсруулах үйлдвэр
барих төслийн талаар авах зарим
арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтад заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамыг тогтоосугай.
2. “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийг холбогдох хууль тогтоомжийн дагуу баталж, мөрдүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгасугай.
3. Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий тосоор найдвартай хангах асуудлаар холбогдох байгууллага, компанитай уулзалт, хэлэлцээр хийж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн нарт үүрэг болгосугай.
4. Газрын тос боловсруулах үйлдвэрийн түүхий тос дамжуулах хоолойн техник, технологийн шийдлийг сонгох, санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх талаар санал боловсруулж танилцуулахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгасугай.
5. Бүгд Найрамдах Энэтхэг Улсын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлэх “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн менежментийн зөвлөх компанийг сонгон шалгаруулах ажлыг эрчимжүүлж, төслийн үе шатны ажлуудыг шуурхай зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгасугай.
6. Үйлдвэрийн байршил хүртэлх дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын явц, гүйцэтгэл, зээлийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т, төсөл хэрэгжүүлэгч компанийг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт тус тус даалгасугай.

7. Газрын тос боловсруулах үйлдвэрийг шаардлагатай усаар хангах асуудлыг Байгаль орчин, ногоон хөгжлийн яам (хуучин нэрээр)-ны Усны нөөцийн зөвлөлийн 2014 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн 2014/5 дугаар тогтоолыг хянан үзэж шийдвэрлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Уул уурхай, хүнд
үйлдвэрийн сайд

У.ХҮРЭЛСҮХ

Д.СУМЪЯАБАЗАР